



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

123 /123/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.08.30

ҮЙЛ ЯВДАЛ

ОЛОН УЛСЫН "АРАВТ" МОРИН ЦЭРГИЙН УРАЛДААНЫ АВАРГУУД ТОДОРЛОО



Олон улсын "Аравт" морин цэргийн уралдаан Тува Улсын нийслэл Кызыл хотноо амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Тус тэмцээнд ОХУ, Монгол, Казахстан, Узбекистан зэрэг улсын Зэвсэгт хүчнээс баг тамирчид оролцсон бөгөөд

Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид өрсөлдөгчдөөсөө ур чадварын хувьд илүү байлаа. Тэмцээний нэгдсэн дүнгээр нэгдүгээр байрт ОХУ, хоёрдугаар байрт Монгол Улс, Узбекстан Улс, гуравдугаар байрт Казахстан Улсын морьт тасгууд шалгарав. "Аравт"

морин цэргийн уралдааны нэг төрөл болох морьт хөтөлгөчдийн тэмцээнд Монгол Улсын багийн тамирчин, ахлагч М.Ням, дэд ахлагч Г.Билгүүн нар хамгийн богино хугацаанд хөтөлж түрүүлэн цомын эзэд боллоо. Монгол Улсын Зэвсэгт хүчний багийн ахлагчаар ЗХЖШ-ын

АУГ-ын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, дасгалжуулагчаар ЗХЖШ-ын СБЗХ-ийн БТСТ-ын дарга, МУГД, хурандаа Д.Цог-Эрдэнэ нар ажилласан бөгөөд Зэвсэгт хүчний 013, 084, 123, 124, 327, 330, 350 дугаар ангиас 16 тамирчин цэргийн алба хаагч оролцлоо.

ХАГАС ШИГШЭЭД ШАЛГАРАВ




Өчигдөр буюу 2021.08.29-ний өдөр "Танкийн биатлон 2021" олон улсын тэмцээнд оролцож байгаа Монголд Улсыг Зэвсэгт хүчний багийн ахмад Р.Ариунболд захирагчтай 3 дугаар экипаж уралдлаа. Тус экипаж 24 минут 14 секунд ажилттайгаар устгах ёстой байгаа бүрэн устгаж гараандаа 2 дугаар байр эзэлсэн амжилт үзүүлээ. Ингэснээр манай баг ганцаарчилсан уралдааны төрөлд устгах ёстой 15 байгаа бүрэн устгаж, нийт 1.14.31 цагийн амжилттайгаар 7 дугаар байранд орж буухиа уралдаанд

оролцох болзол хангасан байна. Тус тэмцээн нь ганцаарчилсан болон буухиа уралдаан гэсэн 2 үеэр зохион байгуулагддаг ба нэгдүгээр дивизионд оролцсон 11 багаас 8 баг буухиа уралдаан буюу хагас шигшээд шалгарч, хагас шигшээ уралдаанаас 4 баг шигшээ уралдаанд шалгарах зарчмаар явагддаг байна. Ташрамд сонирхуулахад манай баг тамирчид өнөөдөр хагас шигшээгийн өнгө дарааллаа сонгоно.

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ ДАЙЧИД ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНД ТОХИЖИЛТЫН АЖИЛ ӨРНҮҮЛЭВ

Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Төлөвлөлт, сургалтын офицерууд болон цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчид бэлэн байдлын дадлагын дохиогоор Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд тогтоосон хугацаанд цугларч, бие бүрэлдэхүүний дүрэмт хувцас, хувийн бичиг баримт болон аранзанд үзлэг хийлээ. Түүнчлэн цэргийн албыг

биеэр дүйцүүлэн хаагчид Монгол Улсад залуучуудын холбоо үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд иргэдийн эрүүл аюулгүй орчинд амрах, зугаалах орчныг бүрдүүлэх үүднээс дугуйн зам дагасан хамгаалалтын хашлагыг бэхлэх, дотор талбайн гүйлтийн зам дагуух модлог ургамлыг арчлах, хатсан өвсийг хамаа, мод үржүүлгийн талбайд ангилан ялгалт хийх зэрэг үүрэг гүйцэтгэлээ.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 207.422	ЭДГЭРСЭН 187.715	НАС БАРСАН 924
+2422	+2131	+1

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4574	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 173	ЭДГЭРСЭН 4314
+80	+18	+17

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 217,202,448

Эдгэрсэн
Нийт: 194,097,696

Нас барсан
Нийт: 4,514,861

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 22	🌧️ 6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 34	🌧️ 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.848.0	2.851.0
EUR 🇪🇺	3.350.0	3.360.0
CNY 🇨🇳	440.0	441.0
RUB 🇷🇺	37.40	39.60
JPY 🇯🇵	25.48	26.30
KRW 🇰🇷	2.37	2.50

ЗУРХАЙ

2021.08.30 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 23/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ЦАГААН НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Эд эдлэл идээ ундаа олддоно

Наран ургах, шингэх:

06:08-19:38

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Мунхрахуй

Суудал:

Төмөр

Энэ өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн.

ДОРНЫН ЗУРХАЙ:

Үсээ засуулбал эд эдлэл, идээ ундаа олддоно

МОГОЙД
ХАЗУУЛСАН ҮЕД АВАХ АНХНЫ ТУСЛАМЖ

ХОРГҮЙ МОГОЙ:
• ХАМГААГАХ
• ХАМГААГАХ
• ХАМГААГАХ

ХОРТӨЙ МОГОЙ:
• ХАМГААГАХ
• ХАМГААГАХ
• ХАМГААГАХ

ЦЭРГИЙН ЧУУЛГАД ЗОЧИЛЖ СЭТГЭЛЭЭ СЭРГЭЭЛЭЭ



алхах завшаан тохиолоо. Манай нутгийн уугуул хурандаа Г.Золзаяа энэ чуулгын даргаар ажилладаг юм байна. Офицеруудын ордны тохижилт, өнгө үзэмж, уран бүтээлчдийн амжилт бүтээл, найрсаг дотно харьцаа энэ бүхэн бидний сэтгэлийг хөдөлгөлөө. Мөн уртын дуу, морин хуурын эгшиг аялгуугаар урам зориг, хийморийг маань сэргээсэнд анги хамт олныхоо өмнөөс баярласнаа илэрхийлье. Уран бүтээлийн улам их амжилтыг хүсэн ерөөе" гэв.

Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэхэд бас нэгэн түлхэц болсон эл арга хэмжээг тус чуулгын марктенгийн албаны дарга, дэд хурандаа Р.Өнөржаргал чадварлаг зохион байгуулж дуу хууртай нутгийнхны сэтгэлийг баясгасан юм. Ташрамд дурдахад, тус чуулгын даргаар Дэлгэрхангай сумын уугуул, бэлтгэл хурандаа Д.Болд ажиллаж байжээ.

Дуу хуурын өлгий нутаг Дундговь аймгийн, тэрдундаа Ардын жүжигчин Г.Хайдав, "моринь" хэмээн ард түмэнд алдаршсан Гавьяат жүжигчин Ж.Нансалмаа, өнөө цагт нийтийн дуучдыг тэргүүлж яваа Гавьяат жүжигчин С.Цогтсайхан, СТА Э.Төрмандах зэрэг олон арван дуучдаараа алдартай Дэлгэрхангай суманд 8 дугаар анги төгссөн

VII төгсөлтийнхөн 45 жилийн ойгоо тэмдэглэх ажлын хүрээнд Офицеруудын ордон, ЦДБЭЧ-д зочилж үүх түүх, уран бүтээлтэй нь танилцлаа.

Энэ үеэр ангийн дарга, "ТОБ" группийн ерөнхий зөвлөх С.Батбаяр "Иргэний байгууллагад ажилладаг хүмүүс учраас цэргийн чуулгаар орох нь цөөн байдаг. Өнөөдөр 90 шахам жилийн түүхтэй чуулгын алтан босгыг

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗАРИМ АЛБА ХААГЧИД ХҮМҮҮНЛЭГИЙН АЯНД НЭГДЭВ

Энэ оныг БЗД-ийн хувьд "Дэмжих жил" болгон зарласан. Үүний хүрээд тус дүүргийн Хөгжлийн төвөөс "Сэтгэлийн өглөг" аяныг өрнүүлж ном, сурах бичиг, хичээлийн хэрэгсэл, хувцас тоглоом зэргийг цуглуулан зорилтот бүлгийн хүүхдүүдэд хүргэж байгаа аж. Уг аянд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагууд идэвхтэй оролцож байгаа юм. Тухайлбал, ЦДБЭЧ, Зэвсэгт хүчний 015, 189 дүгээр анги, Батлан хамгаалахын Төв архивын хамт олны халуун сэтгэлийн тусламжийг талархан хүлээн авснаа Хөгжлийн төвийн хамт олон илэрхийллээ. Уг аян цаашид үргэлжилнэ.



ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТООЛЛОГО, ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН ҮЗЛЭГТ АМЖИЛТТАЙ...



Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 089 дүгээр ангид энэ сарын 28-ны өдөр буюу Бямба гарагт тээврийн хэрэгслийн тооллого, техникийн хяналтын улсын үзлэг, шалгалт явагдлаа. Энэ удаагийн үзлэг, шалгалтыг Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны дарга, хурандаа Л.Баярцогтоор ахлуулсан 10 хүний бүрэлдэхүүнтэй комисс явуулж байгаа бөгөөд ангийн авто техник тус бүрд үзлэг, шалгалт

хийв. Ангийн хувьд авто техникийн ямар нэгэн зөрчил дутагдалгүй амжилттай шалгууллаа. Тус шалгалт ангийн техникийн үзлэгээр эхэлж, жолооч нарын дүрмийн мэдлэгийн шалгалтаар үргэлжилсэн. Мөн Тээврийн хяналтын албаны урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах мэргэжилтэн, ахлах дэслэгч Д.Ганхуяг "Ажлын байран дахь хариуцлага" сэдвээр сургалт зохион байгуулснаар өндөрлөсөн

юм. Энэ жилийн улсын үзлэг ангийн түүхт 100 жилийн ойн босгон дээр явагдаж байгаагаараа онцлог бөгөөд ямар нэгэн зөрчил дутагдалгүй амжилттай шалгагдсан нь бие бүрэлдэхүүний дийлэнх хувийг эзэлдэг жолооч нарын их ойдoo барьж буй бэлэг төдийгүй жолооч нарын ажилдаа хандах хандлага, хариуцлага, үр бүтээл, чадвар, зэргийн илэрхийлэл байлаа.



ФОТО АГШИН



Г.Бат-Эрдэнэ